БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

2023.01.03

"ТЭРБУМ" МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД ОЙЖУУЛАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР

Багц №01. Сэлэнгэ сумын "Хулстайн даваа" 15 га талбай, сумын төвөөс 50-55 км, Хангал сумын "Бөхөнгийн өвөр" 10 га талбай, сумын төвөөс 25-30 км газарт шилмүүст модны суулгацаар ойжуулалтыг нийт 25 га талбайд хийх

Багц №02. Орхон сумын "Сүүдэр" 15 га талбай, сумын төвөөс 50 км, Бүрэгхангай сумын "Бунханы эрээн" 15 га талбай, сумын төвөөс 20-25 км, Хишиг-Өндөр сумын "Шархын урд ар" 15 га талбай, сумын төвөөс 25-30 км газарт суулгацаар ойжуулалтын ажлыг нийт 45 га талбайд хийх

Багц №03 Бугат сумын "Гэзэг" 10 га талбай, сумын төвөөс 15 км, Хутаг-Өндөр сумын "Дондогийн булгийн ар байшинт" 10 га талбайд сумын төвөөс 85-95 км зайд бортоготой тарьцаар нийт 20 га, Хутаг-Өндөр сумын "Дондогийн булгийн ар байшинт" суулгацаар 10 га талбайд ойжуулалтын ажлыг нийт 30 га талбай

Нийт 100 га талбайд бортоготой болон шилмүүст модны суулгацаар ойжуулалтын ажлыг гүйцэтгэнэ.

(Сум дундын ойн ангиар талбайг тусгаарлуулж зургийг гаргуулах) ажлыг хийж гүйцэтгэнэ.

Тендерт оролцогч нь дор дурдсан зарчмын шаардлагыг хангасан төсөл боловсруулна

	Шалгуур
Ойжуулалтын ажил гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахад харгалзах үзүүлэлтүүд	"Мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх" чиглэлийн мэргэжлийн байгууллагын эрхтэй байх.
	Ойжуулалтын ажил хийх мэргэжлийн боловсон хүчинтэй байх /тэдгээрийг баталгаажуулах/
	Ойжуулах, ойн зурвас байгуулах ажилд шаардагдах шаардлага хангасан стандартын тарьц, суулгацын нөөцтэй байх. Стандартын шаардлага хангасныг нотлох баримт материалыг ирүүлэх.
	Өмнөх жилүүдэд хийсэн ойжуулалт болон адил төстэй ажлын үр дүн 2-3 жил /акт, хангалттай үнэлгээ, гэрээний хувийг хавсаргах **амьдралт нь 75%-иас** дээш/
	1 га талбайг ойжуулахад стандартын шилмүүст модны бортоготой тарьц 1500 ш, шилмүүс модны суулгац 1200 ш доошгүй байна.

	Ойжуулалт, ойн зурвас байгуулах ажилд шаардлагатай ажлын багаж, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл /баталгаажуулах/
	Бортоготой тарьцын ойжуулалтын амьдралтыг дээшлүүлэх зорилгоор ойжуулалтын **хашаа, хамгаалалтыг тодорхой хэмжээгээр хийж арчлах**
	Ойжуулалтын ажил болон таримал ойг арчлах, хамгаалах талаар захирлын болон ерөнхий инженерээр баталгаажуулсан технологийн карттай байх.
Бэлтгэл ажил	Ойжуулах, мод тарих талаар орон нутгийн иргэд, сурагчдад зориулсан сургалт сурталчилгааг өргөнөөр хийх, иргэдийг татан оролцуулах.
	Ойжуулах ажлын технологийн картыг боловсруулж батлуулах.
	Ойжуулах талбайг тусгаарлах, тэмдэглэх, өнцгүүдэд шон босгох, координатын цэгийг өнцөг бүрт авах/
	Ойжуулах талбайг цэвэрлэх, бэлтгэх, шан, талбар гаргах, чиг тэмдэг тавих
	Тарьц, суулгацыг ачих буулгах, түр хадгалах технологит үйл ажиллагааг хийх
Үндсэн ажил	Тарих талбайн хөрс бэлдэх, арга, технологи.
	Тарьц, суулгах материалыг тарилтад бэлтгэх.
	Баталгаажуулсан технологийн картын дагуу тарилтыг хийж усалгаа, хамгаалалтын асуудлыг шийдвэрлэсэн байх.
	Ойжуулах талбайд тарилт хийхдээ бороо угтуулах болон усалгааг хийх, стандартын тарьцаар тарилтыг хийх
Хамгаалалт нөхөн тарилт хийх.	Ургах чадваргүй болсон тарьц, суулгацыг ухаж авах, нөхөн тарилт хийх талаар тусгаж өгөх.
	Таримал ургамлыг 3 жилийн туршид арчлах, гадны хүчин зүйлээс хамгаалах арга хэмжээ авах.
	Ойжуулсан, ойн зурвасын талбайд мал бэлчээхийг хориглосон анхааруулга бүхий самбар байрлуулах.
	Сумын Засаг даргын захирамж гаргуулах

ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Нийт багцад хамаарна.

Бэлтгэл ажил	Захиалагчаас өгөх ажлын даалгавар, хийх ажлын нэр	Хугацаа
	Ойжуулах талбайн зургийг гаргаж өнцөг бүрээр координатын цэгийг оруулах	25/IV-01/V
	Ойжуулах, мод тарих талаар орон нутгийн иргэд, сурагчдад зориулсан сургалт сурталчилгааг өргөнөөр хийх, иргэдийг татан оролцуулах	1/V
	Тарих ажлын технологийн картыг боловсруулж батлуулах.	30/IV
	Талбайг тусгаарлах, тэмдэглэх, өнцгүүдэд шон босгох.	1/V
	Ойжуулах талбайг цэвэрлэх, бэлтгэх, шан, талбар гаргах, чиг тэмдэг тавих	1/V

	Суулгах материалыг ачих буулгах, түр хадгалах.	6/V
Үндсэн ажил	Ойжуулах талбайн хөрс бэлдэх.	5/V
	Суулгах материалыг тарилтад бэлтгэх.	1/V
	Баталгаажуулсан технологийн картын дагуу тарилт хийх, услах арчлан хамгаалах.	1/V -20/V
Хамгаалах, нөхөн тарилт хийх.	Ургах чадваргүй болсон тарьц, суулгацыг ухаж авах, нөхөн тарилт хийх.	Жил бүрийн 15/X
	Таримал ургамлыг арчлах, гаднын хүчин зүйлээс хамгаалах, хамгаалалтыг сайжруулах	3 жил
	Тухайн сумын засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулах, гэрээний дагуу захирамж гаргуулж, мал бүхий иргэдэд танилцуулах.	1/VI
	Ойжуулсан талбайд мал бэлчээхийг хориглосон анхааруулга бүхий самбар байрлуулах.	1/VI
Тайлан	Ажлын хэсэгт ойжуулсан, ойн зурвас байгуулсан талбайг урьдчилсан байдлаар хүлээлгэн өгөх.	15/X

Гүйцэтгэгч анхаарах зүйлс.

-Төслийг хэрэгжүүлэх арга технологийг тодорхойлон, тухайн газар нутгийн онцлогийг харгалзан технологийг сонгох. Ойг нөхөн сэргээх үр ашигтай, дэвшилтэт арга технологийг хэрэглэх.

-Ойжуулалтын ажлыг 1 га талбайд 1500 ширхэг бортоготой тарьцаар, 1 га талбайд шилмүүст модны суулгацаар 1200 ширхгийг тарих,

-Ойжуулалтын ажлыг батлагдсан технологийн картын дагуу хийж гүйцэтгэнэ.

-Үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг урьдчилан тооцоолно.

-Үе шатны ажлын хуваарийг гаргана.

-Үйл ажиллагааны хүрэх үр дүн. Таримал ургамлын амьдралт намрын тооллогоор 75 хувиас доошгүй байх.

-Таримал ургамлыг 3 жилийн турш арчлан ургуулах талаар төсөлд тусгасан байна.

-Нийт ажилчдын 20-иос доошгүй хувийг орон нутгийн иргэдээс авч ажиллуулах

БОЛОВСРУУЛСАН:
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН Н.ЦАСАНЧИМЭГ

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Г.ДАВААНЯМ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА А.ГАНТӨМӨР